



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 8/36

Улаанбаатар хот

Дүүргийн 2022 оны “Сайн малчин”-г
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны А/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал маллах арга ухааныг эзэмшин, мал сүргийнхээ бүтэц, чанар, удам угсааг сайжруулж, тоо толгойг нэмэгдүүлэхийн зэрэгцээ амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 1 өрхийг малжуулсан дүүргийн 2 дугаар хорооны малчин Алтангэрэлийн Эрдэнэхуягийг 2022 оны дүүргийн “Сайн малчин”-аар шалгаруулан шагнасугай.

2. “Сайн малчин”-ы шагналд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах 200,000 (Хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Холбогдох үйл ажиллагааг зохион байгуулахыг Тохижилт, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL2023 он ажилзахирамж

11230001

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 14 -ны өдрийн 8/36 дугаар
захирамжийн хавсралт



ДҮҮРГИЙН 2022 ОНЫ "САЙН МАЛЧИН" ШАГНАХАД
ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл (модон)	ш	1	55,000	55,000
2	Тууз	ш	1	30,000	30,000
3	Дагалдах мөнгөн шагнал	төгрөг		100,000	100,000
5	Хадаг	ш	1	15,000	15,000
		Нийт			200,000